

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017-2021 онд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Ерөнхийлөгчийн Тамгын газар /З.Энхболд/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Х.БАТТУЛГА